



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: СНАГ-2025/079/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Энхжаргал Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОТГОНСҮХ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025. 03. 14 № 07/1029
танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Сөрөг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв толилуулаагүй байна.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын сөрөг дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

Иргэний нисэхийн үндэсний төвийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 218,263.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайлан материаллаг хэмжээгээр буруу илэрхийлэгдсэн, өргөн тархалттай байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20, 21, 69 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4, 18, 20 дугаар зүйлийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх, ангилал, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Харьяа салбар, нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 32,271.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь өмнөх оноос 13 дахин өссөн;
- Тайлант онд 15,055.1 сая төгрөгийн орлогын, 163,379.8 сая төгрөгийн зарлагын төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлийг харьяа салбар нэгж бүрээр бэлтгэж, тайлагнаагүй, төсвийн хэтрэлт хэмнэлтийг тооцоогүй, батлагдсан төсвийн гүйцэтгэлийг мөнгөн гүйлгээний тайлангаас орлого, зарлагын тохируулсан дүнгээр тооцож, бэлтгээгүйгээс орлого, зарлагын гүйцэтгэлийг баталгаажуулах боломжгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны нийт борлуулалт 17,890.5 сая төгрөг бөгөөд 300.9 сая төгрөгийн борлуулалтын буцаалт, хөнгөлөлт үзүүлж, 17,589.6 сая төгрөгийн цэвэр борлуулалттай ажилласан байна. Нийт орлогын 38.3 хувь буюу 6,860.8 сая төгрөгийг зорчигч үйлчилгээний орлого, 18.0 хувь буюу 3,226.5 сая төгрөгийг шатахуун тээвэрлэлтийн орлого, 26.2 хувь буюу 4,692.3 сая төгрөгийг үйл ажиллагааны бусад орлого, 17.5 хувь буюу 3,110.9 сая төгрөгийг бусад орлого эзэлж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудад 2024-2026 онд хэрэгжүүлэх хамтын гэрээнд байгууллагын ажлын үр дүнг харгалзан тухайн жилийн ашгаас ажилтнуудад тодорхой хувиар үр дүнгийн урамшуулал олгохоор заажээ. Тус төв нь 19,674.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд ИНЕГ-ын 2024 оны А/605 дугаар тушаалаар ажилтнуудад 1.7 сая төгрөг хүртэлх нэмэгдэл урамшуулал олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Иргэний нисэхийн үндэсний төв нь Засгийн газрын 2024 оны 193 дугаар “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай” тогтоолоор төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болж, агаарын навигаци, нисэх буудал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгө, холбогдох баримтыг Иргэний нисэхийн ерөнхий газрын балансаас тус төвийн баланст шилжүүлэх ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулахаар болсон байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,041,583,632.27	81,037,592.09
1.1.2	Дансны авлага	5,893,015,667.58	7,222,550,660.63
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,376,264,214.29	40,284,330.01
1.1.4	Бусад авлага	931,639,213.43	1,932,416,823.24
1.1.6	Бараа материал	16,752,903,757.34	18,627,849,036.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	476,077,968.86	356,160,409.55
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	6,047,500.00	6,047,500.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	26,477,531,953.77	28,266,346,351.52
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	163,499,532,526.51	146,892,640,515.58
1.2.2	Биет бус хөрөнгө	376,568,750,148.38	374,219,208,342.81
1.2.3	Дуусаагүй барилга	524,207,380.95	1,830,515,297.12
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	114,812,046.18	177,114,706.18
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	540,707,302,102.02	523,119,478,861.69
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	567,184,834,055.79	551,385,825,213.21
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	133,857,501.00	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	198,766.86
2.1.1.3	Татварын өр	98,565,632.01	97,407,017.13
2.1.1.4	НДШ - ийн өглөг	114,166.21	3,842,514.83
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	7,547,011.33	7,885,428.55
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	180,887,278.95	121,002,500.36
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	420,971,589.50	230,336,227.73
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Урьдчилж орсон орлого - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	4,686,696,741.60	4,267,618,739.15
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,686,696,741.60	4,267,618,739.15
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,107,668,331.10	4,497,954,966.88
2.3	Эздийн өмч	412,368,205,895.46	406,246,274,346.14
2.3.1	Өмч: - төрийн	371,685,762,540.00	371,685,762,540.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	40,682,443,355.46	34,560,511,806.14
2.3.7	Эздийн өмчийн бусад хэсэг /2.3.8/	1,453,098,485.77	1,149,168,141.37
2.3.9	Хуримтлагдсан ашиг	148,255,861,343.46	139,492,427,758.83
2.3.11	Эздийн өмчийн дүн	562,077,165,724.69	546,887,870,246.34
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	567,184,834,055.79	551,385,825,213.21

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	15,428,683,547.08	17,589,620,875.00
2	Борлуулалтын өртөг	136,668,029,525.39	160,331,914,988.73
3	Нийт ашиг (алдагдал)	(121,239,345,978.31)	(142,742,294,113.73)
4	Түрээсийн орлого	644,780,500.03	659,882,376.68
5	Хүүний орлого	26,543,182.98	52,127,757.80
8	Бусад орлого	223,575,170,966.25	257,938,892,055.54
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,528,461,432.67	1,176,126,247.33
12	Бусад зардал	122,922,840,290.76	133,646,634,139.45
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(24,833,264.28)	4,034,945.35
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(941,757,816.89)	(764,786,107.65)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(22,410,744,133.65)	(19,674,903,472.79)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(22,410,744,133.65)	(19,674,903,472.79)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(22,410,744,133.65)	(19,674,903,472.79)
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	(22,410,744,133.65)	(19,674,903,472.79)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	188,748,848,866.43	233,507,308,320.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	16,684,853,581.18	14,472,928,082.76
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	40,974,068.20	41,202,673.80
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	168,270,118,276.93	214,257,460,761.26
1.1.6	Үндсэн үйл ажиллагааны бусад мөнгөн орлого	1,766,381,413.29	4,055,277,842.40
1.1.6.1	Банк хоорондын гүйлгээ	1,986,521,526.83	680,438,959.78
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	188,883,521,131.21	234,106,342,762.29
1.2.1	Ажиллагчдад төлсөн	69,431,236,779.43	83,465,152,767.38
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	12,196,319,159.27	18,475,493,457.77
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,394,265,830.47	4,795,558,552.49
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,450,394,263.28	6,505,253,076.27
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	2,633,859.41	5,361,577.46
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,004,580,468.99	5,612,714,043.03
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	17,159,127,249.39	17,212,692,582.38
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	146,050,767.13	799,148,992.05
1.2.9	Үндсэн үйл ажиллагааны бусад мөнгөн зарлага	73,663,783,867.01	95,585,951,905.45
1.2.9.1	Банк хоорондын гүйлгээ	3,435,128,886.83	1,649,015,808.01
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(134,672,264.78)	(599,034,442.29)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	26,543,182.98	51,649,529.11
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	26,543,182.98	51,649,529.11
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	323,444,401.00	413,161,127.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	323,444,401.00	413,161,127.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(296,901,218.02)	(361,511,597.89)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(431,573,482.80)	(960,546,040.18)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,473,157,115.07	1,041,583,632.27
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,041,583,632.27	81,037,592.09

Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	388,068,387,740.00	52,588,615,778.23	1,651,888,249.81	137,037,427,054.38	579,346,318,822.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	388,068,387,740.00	52,588,615,778.23	1,651,888,249.81	137,037,427,054.38	579,346,318,822.42
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(22,410,744,133.65)	(22,410,744,133.65)
Өмчид гарсан өөрчлөлт	(16,382,625,200.00)	(11,906,172,422.77)	(198,789,764.04)	33,629,178,422.72	5,141,591,035.91
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	371,685,762,540.00	40,682,443,355.46	1,453,098,485.77	148,255,861,343.45	562,077,165,724.68
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	371,685,762,540.00	40,682,443,355.46	1,453,098,485.77	148,255,861,343.45	562,077,165,724.69
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(19,674,903,472.79)	(19,674,903,472.79)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	(6,121,931,549.33)	(303,930,344.40)	10,911,469,888.16	4,485,607,994.43

2.5 Орлого, зарлагын төлөвлөгөөний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА	163,379,800.4	140,317,509.0	23,062,291.4	85.9
НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ	163,379,800.4	140,317,509.0	23,062,291.4	85.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,796,023.9	133,675,165.9	21,120,858.1	86.4
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	93,408,059.5	88,533,814.8	4,874,244.7	94.8
Үндсэн ба нэмэгдэл цалин	80,552,244.8	88,268,427.4	(7,716,182.6)	109.6
Унаа хоолны хөнгөлөлт	10,965,666.4	170,614.0	10,795,052.4	1.6
Гэрээт ажлын цалин	1,890,148.3	94,773.4	1,795,374.9	5.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,779,605.3	10,967,532.4	812,072.9	93.1
Тэтгэврийн даатгал	7,939,685.0	10,967,532.4	(3,027,847.4)	138.1
Тэтгэмжийн даатгал	934,080.0	-	934,080.0	-
ҮОМШӨ-ий даатгал	755,205.7	-	755,205.7	-
Ажилгүйдлийн даатгал	282,473.5	-	282,473.5	-
Эрүүл мэндийн даатгал	1,868,161.1	-	1,868,161.1	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,012,408.0	4,050,913.8	961,494.2	80.8
Гэрэл, цахилгаан	2,838,852.0	2,190,001.4	648,850.6	77.1
Түлш, халаалт	1,712,797.0	1,305,260.0	407,537.0	76.2
Цэвэр, бохир ус	454,679.0	408,737.2	45,941.8	89.9
Байрны түрээс	6,080.0	146,915.2	(140,835.2)	2,416.4
Хангамж, бараа материалын зардал	7,400,017.0	6,410,213.9	989,803.1	86.6
Бичиг хэрэг	393,119.0	280,388.0	112,731.0	71.3
Тээвэр, шатахуун	5,733,598.0	5,157,250.5	576,347.5	89.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	428,300.0	449,102.7	(20,802.7)	104.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.0	198,062.8	201,937.2	49.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	445,000.0	325,409.9	119,590.1	73.1
Эд хогшил, урсгал засварын зардал	9,229,721.8	4,514,474.2	4,715,247.6	48.9
Багаж, техник, хэрэгсэл	6,626,375.0	2,641,863.5	3,984,511.5	39.9
Тоног төхөөрөмж	3,194,268.0	1,362,846.9	1,831,421.1	42.7
Автомашин	2,573,690.0	662,910.0	1,910,780.0	25.8
Аэродром	449,167.0	361,082.2	88,084.8	80.4
Гал унтраах зардал	409,250.0	255,024.4	154,225.6	62.3
Хөдөлмөр хамгааллын зардал	1,116,776.9	648,883.0	467,893.9	58.1
Урсгал засвар	1,486,569.9	1,223,727.7	262,842.2	82.3
Томилолт, зочны зардал	1,890,000.0	1,733,926.5	156,073.5	91.7
Гадаад албан томилолт	-	5,627.6	(5,627.6)	-
Дотоод албан томилолт	1,890,000.0	1,728,298.9	161,701.1	91.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,855,644.6	15,507,170.9	6,348,473.7	71.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,602,853.0	202,785.9	1,400,067.1	12.7
Мэргэжлийн зөвлөгөө	1,802,500.0	904,672.5	897,827.5	50.2
Мэдээлэл сурталчилгааны зардал	30,000.0	14,428.8	15,571.2	48.1
Харуул, хамгаалалтын зардал	592,021.0	510,610.5	81,410.5	86.2
Холбоо суваг ашигласны хөлс	3,122,674.8	2,572,872.2	549,802.6	82.4
Үл хөдлөх хөрөнгийн татвар	10,130,449.5	9,635,388.1	495,061.4	95.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	411,567.0	264,494.4	147,072.6	64.3

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

Даатгалын үйлчилгээ	2,215,668.9	158,544.2	2,057,124.7	7.2
Тээврийн хэрэгслийн татвар	29,657.6	26,943.1	2,714.5	90.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	661,691.0	58,894.8	602,796.2	8.9
Газрын төлбөр	1,052,103.8	1,024,314.9	27,788.9	97.4
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	33,988.0	16,676.4	17,311.6	49.1
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	33,470.0	22,635.2	10,834.8	67.6
Олон улсын хурал зөвлөгөөн зохион байгуулах	137,000.0	93,909.9	43,090.1	68.5
Бараа үйлчилгээний бусад зардал	4,220,567.7	1,957,119.4	2,263,448.3	46.4
Бараа үйлчилгээний бусад зардал	383,000.7	860,258.2	(477,257.5)	224.6
Түүхий эд, материал	1,364,783.0	314,276.7	1,050,506.3	23.0
Ахмадын сан	540,716.0	442,231.1	98,484.9	81.8
Биеийн тамирын уралдаан, тэмцээн	85,000.0	56,487.8	28,512.2	66.5
Дотоод сургалт	270,248.0	242,971.5	27,276.5	89.9
Гадаад сургалт	841,750.0	5,071.5	836,678.5	0.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	735,070.0	35,822.6	699,247.4	4.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,583,776.5	6,642,343.2	1,941,433.3	77.4
Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	357,423.5	52,389.4	305,034.1	14.7
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг				
Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж	1,890,383.0	2,561,246.4	(670,863.4)	135.5
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,800,000.0	3,924,378.2	1,875,621.8	67.7
Эмчилгээний төлбөр	483,670.0	104,329.2	379,340.8	21.6
Нүүлгэн шилжүүлэх зардал	52,300.0	-	52,300.0	
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	15,055,142.0	16,621,467.3	(1,566,325.3)	110.4
Буулт, хөөрөлтийн орлого	387,685.0	1,089,059.6	(701,374.6)	280.9
Зорчигч үйлчилгээний орлого	126,250.0	69,914.7	56,335.3	55.4
Бусад орлого	14,541,207.0	15,462,493.0	(921,286.0)	106.3

Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 218,263.5 сая төгрөгийн 67 зөрчил илэрснээс, 3.2 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 6.3 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 188,064.2 сая төгрөгийн 20 албан шаардлага хүргүүлж, 30,189.8 сая төгрөгийн 39 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Өглөгийг дутуу тусгасан.	1	3,200.0			1	3,200.0	1	3,200.0				
	Нийт дүн	1	3,200.0			1	3,200.0	1	3,200.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИНҮТ – нэгтгэл								
	Тайлант онд 14,613.7 сая төгрөгийн орлогын, 141,194.2 сая төгрөгийн зарлагын төлөвлөгөөний гүйцэтгэлийг харьяа салбар, нэгж тус бүрээр тайлагнаагүй, мөнгөн гүйлгээний тайлангаас мөнгөн тохируулгын дүнг бэлтгээгүйгээс тайланг баталгаажуулах боломжгүй.	1	155,807,981.0			1	155,807,981.0		
	Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа, салбар нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 32,271.7 сая төгрөгийн 63 зөрчил илэрсэн. Дотоод хяналт үр нөлөөгүй, сул байгаагаас залруулагдаагүй алдаа, зөрчил өмнөх оноос 13.2 дахин өссөн.	1	-			1	-		
	Санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад хуулиар тогтоосон хугацаанд ирүүлээгүй, хоцроож ирүүлсэн, Гэрэл, суулт, цахилгаан хангалтын алба санхүүгийн тайлангаа бэлтгэж, ирүүлээгүй. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан.	1	30,183,790.9			1	30,183,790.9		
	Тус төвийн ашигладаг санхүү, нягтлан бодох бүртгэлийн Veritech ERP программ нь санхүүгийн тайлан, мэдээг хууль, тогтоомжоор баталсан загварын дагуу, нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг шаардлага хангахуйц хэмжээнд боловсруулж, бэлтгэдэггүй.	1	-					1	-
	Нийт дүн	4	185,991,771.9	-	-	3	185,991,771.9	1	-
2	ИНҮТ – аппарат								
	Аэромонголиа ХХК нь ХУД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүгчийн 2021 оны захирамжийн дагуу 2024 онд 483.2 сая төгрөгийг төлж барагдуулахаар харилцан тохиролцсон боловч 105.0 сая төгрөг төлж, 704.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй,	1	878,418.2			1	878,418.2		

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	Тайлант оны эцэст 472.2 сая төгрөгийн авлага, 27.9 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр, харьяа байгууллагуудын санхүүжилтийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.								
	Санхүүгийн тайлангийн тодруулгыг баталсан загварын дагуу бэлтгээгүй; Тайлант онд 1,379.0 сая төгрөгийн орлогын, 52,690.6 сая төгрөгийн зарлагын төлөвлөгөөний гүйцэтгэлийг тайлагнаагүй; Мөнгөн гүйлгээний тайлангаас мөнгөн тохируулгын дүнг бэлтгэж гаргаагүйгээс тайланг баталгаажуулах, хэтрэлт, хэмнэлтийг хянах боломжгүй.	1	-			1	-		
	Хэрэгцээ шаардлага, зориулалт тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 10.8 сая төгрөгийн бараа материал, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй 398.6 сая төгрөгийн томилолтын тайлан бэлтгээгүй.	1	409,490.1			1	409,490.1		
	Урьдчилж төлсөн зардал 238.4 сая төгрөгийн дэлгэрэнгүй тооцооллыг хөтлөөгүй.	1	238,444.2					1	238,444.2
	Тайлант онд бараа материалын тайлан бэлтгээгүй, 304.8 сая төгрөгийн бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй.	1	304,763.4					1	304,763.4
	1. Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд байрлалтай 25979 м.кв нарны энергийн системийн байгууламжийн зориулалт бүхий газар ИНЕГ-ын нэр дээр бүртгэлтэй, 2. Үндсэн хөрөнгийн тайлан бэлтгээгүй, тооллогыг холбогдох журмын дагуу зохион байгуулаагүй, тайлант оны эхэнд 79.0 сая төгрөгийн анхны өртөгтэй, үлдэгдэл өртөггүй 113 хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон данснаас хасах асуудлыг шийдвэрлээгүй.	1	-					1	-
	Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээр нийт 18,905.3 сая төгрөг олгохоор тооцсон бөгөөд цалингийн тодотгох, албан хаагчдад олгох цалингийн жагсаалтыг байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогч батлаагүй, сард 392-563 ажилтанд цалин олгодог бөгөөд сар бүрийн цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийн тооцоолол зөрүүтэйгээс цалингийн зардлыг баталгаажуулах боломжгүй; Хамтын гэрээнд байгууллагын ашгаас ажилтнуудад тодорхой хувиар үр дүнгийн урамшуулал олгохоор заасан бөгөөд байгууллага алдагдалтай ажилласан байхад 467 ажилтанд нийт 695.8 сая төгрөгийн оны урамшуулал олгосон.	1	19,601,192.4					1	19,601,192.4
	Нийт дүн	7	21,432,308.3	-	-	3	1,287,908.3	4	20,144,400.0
3	ГТҮШХА								
	Тайлант онд 47,358.3 мянган төгрөгийн авлага, 3,223.9 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй.	1	50,582.2			1	50,582.2		
	Санхүүгийн тайлангийн тодруулгыг батлагдсан загварын дагуу бэлтгээгүй, 933,220.0 мянган төгрөгийн орлогын, 11,158,930.0 мянган төгрөгийн зардлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг гаргахдаа мөнгөн гүйлгээний тайлангаас орлого зарлагын мөнгөн тохируулгын дүнг бэлтгэж, гаргаагүйгээс тайланг баталгаажуулах, төсвийн хэтрэлт, хэмнэлтийг хянах боломжгүй.	1	-			1	-		

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	Тайлант оны эхэнд үлдэгдэл өртөггүй 380 ширхэг бараа материал бүртгэлтэй, бараа материалын өртгийг (-) хасах дүнгээр бүртгэж, 17,389.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.	1	17,389.2					1	17,389.2
	Санхүүгийн тайланд бүртгэлтэй 8,643,552.0 мянган төгрөгийн 3 газар ИНЕГ-ын нэр дээр бүртгэлтэй; ТӨБЗГ-ын 2023 оны 93 дугаар тогтоолоор 5,344,460.8 мянган төгрөгийн үнэлгээ бүхий шатахуун түгээх станцын 59648 мкв газрыг МИАТ ХХК-аас балансаас баланст шилжүүлэн авсан. Тайлант онд тус газрын зориулалтыг үйлчилгээтэй орон сууц болгон өөрчлөн гэрчилгээ авсан.	1	5,344,460.8					1	5,344,460.8
	Цалингийн тодотгох, албан хаагчдад олгохоор тооцсон цалингийн жагсаалтыг байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогч батлаагүй; Хамтын гэрээнд байгууллагын ашгаас ажилтнуудад тодорхой хувиар үр дүнгийн урамшуулал олгохоор заасан бөгөөд байгууллага алдагдалтай ажилласан байхад 172 ажилтанд нийт 270,441.7 мянган төгрөгийн оны урамшуулал олгосон.	1	270,441.6					1	270,441.6
	Нийт дүн	5	5,682,873.8	-	-	2	50,582.2	3	5,632,291.6
4	НХНАА, НЖЗШНА, НУТА, ОХЗЛ, НХҮА, НМҮА								
	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй Дорноговь аймгийн Сайншанд суман дахь 50,728.4 мянган төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 68.9 м.кв 2 өрөө орон сууц хувь хүний нэр дээр бүртгэлтэй, хөдөө орон нутагт байрлах 172,000.0 мянган төгрөгийн үнэлгээ бүхий 5 газар газар эзэмших эрхийн гэрчилгээгүй; Санхүүгийн тайланд бүртгэлтэй 1,299,650.0 мянган төгрөгийн үнэлгээ бүхий 11 газар ИНЕГ-ын нэр дээр бүртгэлтэй.	1	222,728.3			1	222,728.3		
	Үндсэн хөрөнгийн тооллогыг холбогдох журмын дагуу зохион байгуулаагүй, тооллогыг санхүү бүртгэлийн ажилтан хийсэн бөгөөд үр дүнг тооллогын комиссоор хэлэлцүүлээгүй; Тайлант оны эхэнд НХНАА-нд өртөггүйгээр 645 ширхэг бараа материал бүртгэлтэй; Үндсэн хөрөнгийн дансанд нийт 4,507,982.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй 229 ширхэг хөрөнгийн үлдэгдлийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон данснаас хасах асуудлыг шийдвэрлүүлээгүй.	1	-					1	-
	- Цалингийн тодотгох, албан хаагчдад олгохоор тооцсон цалингийн жагсаалтыг байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогч батлаагүй; - Олгохоор тооцсон цалин цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээс 9,290.0 мянган төгрөгөөр, гарт олгохоор тооцсон цалингаас 1,762,324.6 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй; - "ИНЕГ, түүний харьяа байгууллагуудад 2024-2026 онд хэрэгжүүлэх хамтын гэрээ"-нд байгууллагын ашгаас ажилтнуудад тодорхой хувиар үр дүнгийн урамшуулал олгохоор заажээ. Тайлант онд -19,674,903.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд ажилтнуудад нийт 758,407.4 мянган төгрөгийн оны урамшуулал олгосон.	1	2,530,022.2					1	2,530,022.2

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	Санхүүгийн тайлангийн тодруулгыг баталсан загварын дагуу бэлтгээгүй, 2024 онд 855,000.0 мянган төгрөгийн орлогын, 46,630,041.0 мянган төгрөгийн зарлагын төлөвлөгөөний гүйцэтгэлийг мөнгөн гүйлгээний тайлангаас орлого, зарлагын тохируулсан дүнгээр бэлтгэж, гаргаагүйгээс тайланг баталгаажуулах, хэтрэлт, хэмнэлтийг хянах боломжгүй.	1	-					1	-
	Нийт дүн	4	2,752,750.5	-	-	1	222,728.3	3	2,530,022.2
5	Жаргалант сэргээн засах амралт								
	Тайлант хугацаанд 29,692.1 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй үүнээс 21,971.7 мянган төгрөгийн авлага 2005 оноос үүссэн, хөөн хэлэлцэх хугацаа дууссан найдваргүй авлагатай байна.	1	25,819.4			1	25,819.4		
	- Тайлант онд 6 удаагийн тээврийн хөлс 900.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу, тээврийн тооцоогүйгээр олгосон. - Шинэчлэн баталсан бүтцээр "Жаргалант" сэргээн засах амралтын бүтцээс хасагдсан Нисэхийн спорт цогцолборын үндсэн орон тооны 25 ажилтны 1-5 сарын цалин 164,247.6 мянган төгрөг, гэрээт 13 ажилтны 1-4 сарын цалин 39,006.4 мянган төгрөг, нийт 203,254.0 мянган төгрөгийг тус амралтын газрын төсвөөс олгосон, - Цалингийн зардлыг анхан шатны баримт, ерөнхий журнал, баталсан төсөв, бүтэц орон тоотой тулган баталгаажуулахад дээрх ажилтнуудын цалингаас шалтгаалан их хэмжээний зөрүү үүссэнийг хянах боломжгүй.	1	204,154.0			1	204,154.0		
	Тайлант онд борлуулалтын орлого батлагдсан төлөвлөгөөнөөс 31,170.0 мянган төгрөгөөр тасарсан.	1	31,170.0			1	31,170.0		
	- ИНЕГ-н даргын 2024 оны А/627 дугаар тушаалаар салбар хооронд шилжүүлэх 21 нэр төрлийн 25,598.0 мянган төгрөгийн 245 ширхэг хөрөнгийг 126 ширхгээр дутуу бүртгэсэн; - Санхүүгийн байдлын тайлангийн дүн, үндсэн хөрөнгө дансны үлдэгдлээс 7.2 мянган төгрөгийн зөрүүтэй.	1	25,605.3					1	25,605.3
	- Тайлант онд цалингийн тодотгох, дэлгэрэнгүй жагсаалтыг дарга, ерөнхий нягтлан бодогч батдаагүй; - Хамтын гэрээнд заасан байгууллагын тухайн жилийн ашгаас тооцож ажилтнуудад жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг тооцож олгох заалтыг зөрчин, алдагдалтай ажилласан нөхцөлийг харгалзалгүй 67,433.3.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	67,433.3					1	67,433.3
	Нийт дүн	5	354,182.0	-	-	3	261,143.4	2	93,038.6
6	НАБХА								
	Дотоод албан томилолтын 10,540.0 мянган төгрөгийн томилолтын тайлан бэлтгээгүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Тайлант хугацаанд нэр бүхий байгууллагаас "Нислэгийн үед хэрэглэгдэх хангамжийн эд зүйлс, хоол хүнсэнд нислэгийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний хугацаа хэтрүүлэн төлсөн 5,7,9-р сарын нийт 30,000.0 мянган төгрөгийн төлбөрт алданги тооцоогүй.	1	40,540.0			1	40,540.0		

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	Тайлант хугацаанд 4,901.8 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, 5,247.4 мянган төгрөгийн авлага удаан жилийн насжилттай.	1	4,901.8			1	4,901.8		
	- ТӨБЗГ-ын 2024 оны 582 дугаар "Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай" тогтоолын дагуу акталсан хөрөнгийн балансын үнийг тодруулга тайланд тогтоолд зааснаас 4,940.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан; - ИНЕГ-ын даргын 2024 оны А/274, А/627 дугаар "Үндсэн хөрөнгө салбар хооронд шилжүүлэх тухай" тушаалаар НАБХА-нд шилжүүлсэн хөрөнгийг бүртгэхдээ нийт 10 хөрөнгийн өртгийг 7,985.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн, 2,727.0 мянган төгрөгийн 1 хөрөнгийг бүртгээгүй; - ИНЕГ-ын 2024 оны 05/2980 дугаартай албан бичгээр ирүүлсэн хөрөнгө худалдан авах зөвшөөрлийн дагуу хөрөнгө бэлтгэхдээ тус тушаалд тусгаагүй 5 нэр төрлийн 10 ширхэг 20,101.4 мянган төгрөгийн хөрөнгийг нэмж худалдан авч бүртгэсэн.	1	15,652.5					1	15,652.5
	- Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн цалин ба нэмэгдэл цалингийн нийт дүн, хоолны зардлыг цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээс нийт 27,054.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан; - Цалингийн дэлгэрэнгүй бүртгэл, гарт олгосон дүнгээс 21,385.5 мянган төгрөгийн зөрүүтэй; - Тайлант онд цалингийн тодотгох, дэлгэрэнгүй жагсаалтыг дарга, ерөнхий нягтлан бодогч батлаагүй; - Хамтын гэрээнд заасан байгууллагын тухайн жилийн ашгаас тооцож ажилтнуудад жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг тооцож олгох заалтыг зөрчин, алдагдалтай ажилласан нөхцөлийг харгалзалгүй 670,675.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	719,114.9					1	719,114.9
	Нийт дүн	4	780,209.2	-	-	2	45,441.8	2	734,767.4
7	ШХА								
	ИНЕГ-н даргын 2024 оны А/274, А/627 дугаар "Үндсэн хөрөнгө салбар хооронд шилжүүлэх тухай" тушаалаар Шатахуун хангалтын албанд шилжүүлсэн хөрөнгийг бүртгэхдээ 847.0 мянган төгрөгийн 2 хөрөнгийг илүү, 2,778.8 мянган төгрөгийн 2 хөрөнгийг дутуу бүртгэсэн;	1	3,625.8					1	3,625.8
	- Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн бусад нэмэгдлийг цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээс нийт 2,443.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан; - Цалингийн дэлгэрэнгүй бүртгэл, гарт олгосон дүн 7,612.2 мянган төгрөгийн зөрүүтэй; - Тайлант онд цалингийн тодотгох, дэлгэрэнгүй жагсаалтыг дарга, ерөнхий нягтлан бодогч батлаагүй; - Хамтын гэрээнд заасан байгууллагын тухайн жилийн ашгаас тооцож ажилтнуудад жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг тооцож олгох заалтыг зөрчин, алдагдалтай ажилласан нөхцөлийг харгалзалгүй 69,133.3 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	79,189.5					1	79,189.5
	Нийт дүн	2	82,815.3	-	-	-	-	2	82,815.3

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

8	БУОУНБ								
	БУОУНБ нь 22 иргэн, аж ахуйн нэгжтэй "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ" байгуулсан бөгөөд гэрээнд заасан алдангийг тооцоогүй.	1	-			1	-		
	Тайлант хугацаанд 46,527.1 мянган төгрөгийн авлага, 53,268.9 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй. Нийт 49,903.6 мянган төгрөгийн авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.	1	99,796.0			1	99,796.0		
	- ИНЕГ-н даргын 2024 оны А/274, А/627 дугаар "Үндсэн хөрөнгө салбар хооронд шилжүүлэх тухай" тушаалаар БУОУНБ-д шилжүүлсэн хөрөнгийг бүртгэхдээ 13,998.9 мянган төгрөгийн 3 хөрөнгийг дутуу, нийт 5 хөрөнгийг 43,165.3 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн; - ИНЕГ-н даргын 2024 оны А/274 дүгээр "Үндсэн хөрөнгө салбар хооронд шилжүүлэх тухай" тушаалаар БУОУНБ-аас НЭМСЗА-д шилжүүлсэн 7,700.0 мянган төгрөгийн 1 хөрөнгийг хасалт хийгээгүй үлдэгдэлтэй;	1	57,164.2					1	57,164.2
	- Олгохоор тооцсон цалин, цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээс 17,193.2 мянган төгрөгийн зөрүүтэй; - Тайлант онд цалингийн тодотгох, дэлгэрэнгүй жагсаалтыг дарга, ерөнхий нягтлан бодогч батлаагүй; - Хамтын гэрээнд заасан байгууллагын тухайн жилийн ашгаас тооцож ажилтнуудад жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг тооцож олгох заалтыг зөрчин, алдагдалтай ажилласан нөхцөлийг харгалзалгүй 153,009.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	170,202.7					1	170,202.7
	Нийт дүн	4	327,162.9	-	-	2	99,796.0	2	227,366.9
	Орон нутгийн нисэх буудлууд								
1	Баянхонгор нисэх буудал								
	Томилолтын зардлыг илүү олгосон.	1	400.0	1	400.0				
	Нэг албан хаагчийн цалин 484.0 мянган төгрөгийг НДШ-ийн тайланд илүү мэдээлсэн.	1	484.0					1	484.0
	НДШ-ийн тайлангаарх 261.1 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	261.1					1	261.1
	Нийт дүн	3	1,145.1	1	400.0	-	-	2	745.1
2	Булган нисэх буудал								
	Томилолтын зардал олгохдоо хоолны мөнгийг цалингийн зардлаас хасаж тооцоогүй илүү олгосон.	1	600.0	1	600.0				
	Мөнгөн гүйлгээгээр 15,702.0 мянган төгрөгийн шатахууны гүйлгээ хийсэн боловч 480,657.00 төгрөгийн орлогыг тайланд тусгаагүй, юунд зарцуулсан нь тодорхойгүй.	1	480.7	1	480.7				
	Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын комисс томилж тооллого хийсэн гэх боловч хөрөнгийн тооллогын комиссын гишүүдийн үндсэн хөрөнгө болон бараа материалын эцсийн үлдэгдлийн дүнг санхүүгийн тайлангийн дүнтэй тулгахад зөрүүтэй тайлагнасан. Тухайлбал: Барилга байгууламжийн үлдэх өртгийн дүнг -22,210,628.94	1	77,678.7			1	77,678.7		

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	төгрөг, машин тоног төхөөрөмжийн дүнг -53,875,583.62 төгрөг, тавилга эд хогшлын дүнг -1,592, 462.16 төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.								
	Тус байгууллагын нярвын гаргасан шатахууны тайланг шалгахад шатахууны орлого 15,221,342.38 төгрөгийн орлого авч, 15,144,495.74 төгрөгийн зарлагын тооцоо гаргасан боловч батлагдсан маягаар жолоочийн тооцооны хуудсыг хөтлөөгүй, даргын цохолт болон шаардах хуудсаар шатахуун зарцуулалтыг зарцуулаагүй.	1	15,144.5			1	15,144.5		
	Шатахууны 1,253,431.00 төгрөгийн урамшууллын орлого зарлагыг шатахууны тайланд бүрэн тусгаж тайлагнаагүй.	1	1,253.4					1	1,253.4
	ИНЕГ-аас олгосон ТС шатахууны орлого, зарлагын дүнг тооцоо нийлсэн актаар баримтжуулж ажиллаагүй, ИНЕГ-аас 2024 онд 4 удаагийн 44388 кг шатахууны орлого авсан гэх боловч нэгтгэл шатахууны ТС-ийн нярвын тайлангаар 171.93 кг-ын шатахууны орлогыг дутуу буюу зөрүүтэй тайлагнасан.	1	-					1	-
	Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, бусад хөрөнгийг дахин үнэлж нийт 66,823.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тайлагнасан нь холбогдох дээд газраар хянуулж, батлуулаагүй.	1	66,823.3					1	66,823.3
	Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж ажиллаагүй, санхүүгийн тайлангаар тусгасан өглөг авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй.	1	-					1	-
	Нөхөн хангалтаар ирж ажиллаж буй ажилчдын цагийн бүртгэлийг бүртгэж баримтжуулаагүй.	1	-					1	-
	Тус байгууллага нь 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 120001882810 тоот Төрийн банкны дансыг өөрийн байгууллагын нэр дээр нээж ажил гүйлгээг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хийсэн боловч холбогдох харилцах гүйлгээний баримт болон нярвын тайлан баримт материалыг үдэж архивын нэгж болгоогүй.	1	580,128.2					1	580,128.2
	Нийт дүн	10	742,108.8	2	1,080.7	2	92,823.2	6	648,204.9
3	Говь-Алтай нисэх буудал								
	Бодитоор байгаа 11,190.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд зарлагдаж хассан.	1	11,190.0			1	11,190.0		
	Шаардаж хуудсыг тухай бүр бүрэн бичээгүйгээр халаалтын зуухны ээлж хүлээлцэх хуудасны дагуу нүүрсийг шууд зарлагдсан.	1	-					1	-
	Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор нярвын үлдэгдлийг тоолсон нь эд хариуцагчийн бүртгэл, комиссын илтгэх хуудсаар нотлогдохгүй.	1	-					1	-
	Нийт дүн	3	11,190.0	-	-	1	11,190.0	2	-
4	Дундговь нисэх буудал								
	Булган аймаг дахь нисэх буудлын холбоо, навигацийн инженерт ээлжийн амралтын зөрүү 817.4 мянган төгрөгийг Дундговь Нисэх буудлаас олгосон.	1	817.4			1	817.4		
	Улаанбаатар хотод сургалтад хамрагдсан ажилтнуудад албан томиллоор ажилласан ажлын тайлангүй, анхан шатны баримтын	1	6,880.0					1	6,880.0

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	бүрдэл дутуу нийт 6,880.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгосон.								
	- Санхүүгийн тайланд бараа материалын эцсийн үлдэгдлийг бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээс 66.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан; - ТӨБЗГ-ын 2024 оны 582 дугаар "Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай тушаал"-д заасан 290.8 мянган төгрөгийн 1 хөрөнгийг акталж хасалт хийгээгүй үлдэгдэлтэй;	1	357.8					1	357.8
	- Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээс нийт 4,705.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан; - Цалингийн дэлгэрэнгүй бүртгэл, гарт олгосон дүн 1,698.2 мянган төгрөгийн зөрүүтэй; - Тайлант онд цалингийн тодотгох, дэлгэрэнгүй жагсаалтыг дарга, ерөнхий нягтлан бодогч батлаагүй; - Хамтын гэрээнд заасан байгууллагын тухайн жилийн ашгаас тооцож ажилтнуудад жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг тооцож олгох заалтыг зөрчин, алдагдалтай ажилласан нөхцөлийг харгалзалгүй 16,150.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон;	1	22,553.3					1	22,553.3
	Нийт дүн	4	30,608.5	-	-	1	817.4	3	29,791.1
5	Өвөрхангай нисэх буудал								
	Үндсэн хөрөнгийн тооллогыг журмын дагуу хийгээгүй.	1	-					1	-
	Нийт дүн	1	-	-	-	-	-	1	-
6	Өмнөговь нисэх буудал								
	Дотоод томилолтын 61,129.9 мянган төгрөгийн томилолтын хуудсыг байгууллагын дарга олгох хувь хэмжээг бөглөөгүй.	1	61,129.9					1	61,129.9
	Бараа үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн И баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсаргасан.	1	-					1	-
	Цалингийн урьдчилгаа олгохдоо батлагдсан загварыг ашиглаагүй.	1	-					1	-
	Түлш шатах тосох материалын зарцуулалтын тайланг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан загварын дагуу хөтлөөгүй.	1	-					1	-
	Нийт дүн	4	61,129.9	-	-	-	-	4	61,129.9
7	Ховд нисэх буудал								
	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийсэн аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний төлбөрийг шилжүүлэхдээ 1,750.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн.	1	1,750.0	1	1,750.0				
	Түлш халаалтын зардлыг тендер зарлаагүйгээр шууд гэрээ байгуулсан.	1	-					1	-
	Нийт дүн	2	1,750.0	1	1,750.0	-	-	1	-
8	Хөвсгөл нисэх буудал								

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	Тус байгууллагын Тэвхэн ХХК-аас худалдан авсан материалыг тулган баталгаажуулахад 2.3 сая төгрөгийн албан бус хэрэгцээний байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй материал худалдан авсан.	1	2,302.1	1	2,302.1				
	Тайлант онд нисэх буудлын үйлчилгээ хариуцсан зохион байгуулагчаар шинээр ажилтан томилж 2024 оны 9 дүгээр сарын 23-аас 12 дугаар сарын 13-ны өдөр хүртэл ажиллаж 5.2 сая төгрөгийн цалин авсан боловч үндсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.	1	5,222.4					1	5,222.4
	Нийт дүн	2	7,524.5	1	2,302.1	-	-	1	5,222.4
9	Хэнтий нисэх буудал								
	Цалинг давхардуулан олгосон	1	607.6	1	607.6				
	Цалингийн авлага бүртгээгүй	1	150.0	1	150.0				
	Нийт дүн	2	757.6	2	757.6				
	НИЙТ ДҮН	66	218,260,288.2	7	6,290.4	20	188,064,202.5	39	30,189,795.4

3.2 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар нийт 13,134.4 сая төгрөгийн 34 зөрчил илэрснээс, 697.7 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 12,436.7 сая төгрөгийн 30 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
				Үүнээс						
		Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИНҮТ нэгтгэл									
	ИНЕГ, түүний харьяа байгууллагуудад 2024-2026 онд хэрэгжүүлэх хамтын гэрээнд байгууллагын ажлын үр дүнг харгалзан тухайн жилийн ашгаас ажилтнуудад тодорхой хувиар үр дүнгийн урамшуулал олгохоор заажээ. Тус төв нь -19,674.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байхад ИНЕГ-ын 2024 оны А/605 дугаар тушаалаар ажилтнуудад 1.7 сая төгрөг хүртэлх нэмэгдэл урамшуулал олгосон.	1	-					1	-	
	Түүвэрт хамрагдсан 12 байгууллагын илүү цагийг түүвэрлэн шалгахад ажилтнуудыг нийт 185353 цагаар илүү ажиллуулж, 3,593.5 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь бүтэц, орон тоог оновчтой, зөв төлөвлөсөн эсэх, цалин хөлсийг үр дүн, ашигтай нь уялдуулан олгож байгаа эсэхийг үнэлэх боломжгүй.	1	3,593,479.0	-	-	-	-	1	3,593,479.0	
	Нийт дүн	2	3,593,479.0	-	-	-	-	2	3,593,479.0	
2	ИНҮТ аппарат									

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	- Байгууллагын цахим сургалтад ашиглах багц видео контент хийх ажилд 16.1 сая төгрөг; - ХАБЭА-н онлайн сургалтыг нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааны зардалд 3.7 сая төгрөгийг зарцуулсан нь баримтаар нотлогдохгүй.	1	19,750.0			1	19,750.0		
	Өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд бүтцийн өөрчлөлтөөр орон тоо хасагдсан үндэслэлээр 8 ажилтанд 637,423.7 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон. Тухайлбал, Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газрын тооцооны нягтлан бодогчийн орон тоо хасагдсанаас ИНҮТ-ийн даргын 2024 оны А/87 дугаар тушаалаар нэр бүхий ажилтныг ажлаас чөлөөлж, ИНЕГ-ын даргын Б/114 дүгээр тушаалаар 25,887.6 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон бөгөөд шүүхийн шийдвэр, магадлалыг үндэслэн тухайн ажилтныг ажилд эргүүлэн авсан.	1	637,423.7			1	637,423.7		
	Тайлант онд давхардсан тоогоор 532 ажилтанд нийт 14426 илүү цагийг тооцож, 400.5 сая төгрөгийн цалин олгосон нь байгууллагын бүтэц, орон тоог оновчтой төлөвлөсөн эсэхийг үнэлэх боломжгүй.	1	400,464.7					1	400,464.7
	Шилэн дансны цахим мэдээллийн санд нийт 244,601.5 сая төгрөгийн орлого, зарлагын 1022 гүйлгээ мэдээлэхээс 335.6 сая төгрөгийн 21 гүйлгээ, төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой 20 тушаал, шийдвэрийг мэдээлээгүй.	1	335,643.4					1	335,643.4
	Нийт дүн	4	1,393,281.8	-	-	2	657,173.7	2	736,108.1
3	ГТҮШХА								
	Тайлант онд давхардсан тоогоор 539 ажилтанд нийт 23016 илүү цагийг тооцож, 439,270.2 мянган төгрөгийн цалин олгосон нь байгууллагын бүтэц, орон тоог оновчтой төлөвлөсөн эсэхийг үнэлэх боломжгүй.	1	439,270.2					1	439,270.2
	Нийт дүн	1	439,270.2	-	-	-	-	1	439,270.2
4	НХНАА, НЖЗШНА, НУТА, ОХЗЛ, НХҮА, НМУА								
	Дотоод томилолтын зардлыг байгууллагын даргын тушаалаар батлуулаагүй, тээврийн зардлыг томилолтын төсөвт тусгаагүй.	1	-					1	-
	Шилэн дансны цахим мэдээллийн санд нийт 40,672,916.4 мянган төгрөгийн 165 орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээс 3,348,622.4 мянган төгрөгийн 11 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	3,348,622.3					1	3,348,622.3
	Тайлант онд 3 нэгж хэсгийн давхардсан тоогоор 1065 ажилтанд нийт 27431 илүү цагийг тооцож, 1,437,903.3 мянган төгрөгийн цалин тооцож олгосон нь байгууллагын бүтэц, орон тоог оновчтой төлөвлөсөн эсэхийг дүгнэх боломжгүй.	1	1,437,903.3					1	1,437,903.3
	Нийт дүн	3	4,050,526.6	-	-	-	-	3	4,050,526.6
5	Жаргалант сэргээн засах амралт								
	Жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад хуулиар тогтоосон хугацаанд ирүүлээгүй.	1	-					1	-

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	Байгууллагын бүтэц, орон тоо, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулаагүй, тайлант хугацаанд ажилтнуудыг 2135 цагаар ажиллуулж 37,016.7 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон.	1	37,016.6					1	37,016.6
	Шилэн дансны мэдээллийн цахим санд нийт 2,185,513.3 мянган төгрөгийн 67 ажил гүйлгээ мэдээлэхээс 26,545.8 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй.	1	26,545.8					1	26,545.8
	Бараа материалын тооллогоор 2021 оноос эхлэн худалдан авч нөөцөлсөн, хугацаа нь дууссан 14 нэр төрлийн 861.4 мянган төгрөгийн дүнтэй бараа материалын үлдэгдэлтэй.	1	861.4					1	861.4
	Нийт дүн	4	64,423.8	-	-	-		4	64,423.8
6	НАБХА								
	Жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад хуулиар тогтоосон хугацаанд ирүүлээгүй.	1	-					1	-
	Ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжгүй 384.2 мянган төгрөгийн 368 ширхэг бараа материал байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангахгүй.	1	384.2					1	384.2
	Байгууллагын бүтэц, орон тоо, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулаагүй, тайлант хугацаанд ажилтнуудыг 104,919 цагаар ажиллуулж 995,878.2 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон.	1	995,878.2					1	995,878.2
	Шилэн дансны мэдээллийн цахим санд нийт 18,516,724.8 мянган төгрөгийн 84 ажил гүйлгээ мэдээлэхээс 1,433,644.2 мянган төгрөгийн 9 гүйлгээг мэдээлээгүй.	1	1,433,644.2					1	1,433,644.2
	Нийт дүн	4	2,429,906.6	-	-	-		4	2,429,906.6
7	ШХА								
	Жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад хуулиар тогтоосон хугацаанд ирүүлээгүй.	1	-					1	-
	ИНҮТ-өөс шатахуун хангалтын албанд шатахуун хадгалуулах, сумалгаа хийлгэхтэй холбоотой харилцааг зохицуулах "Агаарын хөлгийн шатахуун хадгалах, ачих, цэнэглэх үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г 6 компанитай тус тус байгуулсан. Гэрээний хэрэгжилтийг шалгахад дараах зөрчлүүд илэрч байна. Үүнд: 1. Гэрээний 3.12-т талууд сар бүрийн тооцоог дараа сарын эхний 7 хоногт тооцоо нийлэхээр заасан ч гэрээ байгуулсан 5 компанитай зарим саруудад тооцоо нийлээгүй; 2. Гэрээний 7 дугаар зүйлд шатахуун хангамжийн байгууламжид шатахуун хадгалах төлбөр эхний 30 хоногт хоног тутамд 200 төгрөг, 30-аас дээш хоногт хоног тутамд 400 төгрөг байхаар заасан ч хадгалалтын төлбөр тооцох аргачлалгүй, нэр бүхий 2 компани бусад гэрээлэгчдээс хадгалалтын төлбөрийг 200 төгрөгөөр тооцсон; 3. Гэрээнд заасан хугацаа хэтэрсэн төлбөрт алданги тооцоогүй; 4. "Агаарын хөлгийн шатахуун хадгалах, ачих, цэнэглэх үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулаагүйгээр нэр бүхий компанид шатахуун хадгалах, сумлах үйлчилгээг үзүүлсэн.	1	-			1		-	

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	Байгууллагын бүтэц, орон тоо, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулаагүй, тайлант хугацаанд зарим ажилтнуудыг сард 131 хүртэл цаг илүү цагаар ажиллуулж, нийт 7128 цагийн 140,886.8 мянган төгрөгийг илүү цагийн хөлс олгосон.	1	140,886.8					1	140,886.8
	Шилэн дансны мэдээллийн цахим санд нийт 3,035,151.5 мянган төгрөгийн 65 гүйлгээ мэдээлэхээс 308,465.1 мянган төгрөгийн 28 гүйлгээг мэдээлээгүй.	1	308,465.1					1	308,465.1
	Нэр бүхий компанид 150 тонн шатахууныг шатахуун хангалтын албаны агуулахаас олгож буцаан авах нөхцөлтэй "Агаарын хөлгийн ТС-1 төрлийн шатахуун усыг усаар буцаан өгөх нөхцөлтэйгөөр олгох гэрээ"-г байгуулсан. Өөр нэр бүхий компанитай байгуулсан "Агаарын хөлгийн шатахуун хадгалах, ачих, цэнэглэх үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу 7 дугаар сард 150 тонн шатахуун сумалгааны төлбөр 5,412.0 мянган төгрөгийг нэр бүхий компанид гэрээний дагуу олгох шатахуунд тооцож нийт төлбөрөөс суутгасан.	1	5,412.0					1	5,412.0
	Нийт дүн	5	454,763.9	-	-	1	-	4	454,763.9
8	БУОУНБ								
	Жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад хуулиар тогтоосон хугацаанд ирүүлээгүй.	1	-					1	-
	БУОУНБ нь ТӨБЗГ-ын тогтоолгүйгээр ТӨБЗГ-ын 2023 оны 39 дүгээр хуралдааны тэмдэглэлд үндэслэн түрээсийн орлогоос 20 хувиар тооцож 130,028.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.	1	130,028.4					1	130,028.4
	Байгууллагын бүтэц, орон тоо, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулаагүй, тайлант хугацаанд ажилтнуудад 6298 илүү цагийн хөлс 129,653.4 мянган төгрөгийг олгосон.	1	129,653.3					1	129,653.3
	Нийт дүн	3	259,681.7	-	-	-	-	3	259,681.7
	Орон нутгийн нисэх буудал								
1	Баянхонгор нисэх буудал								
	Нүүрс худалдан авахдаа тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн	1	36,949.9					1	36,949.9
	Нийт дүн	1	36,949.9	-	-	-	-	1	36,949.9
2	Дундговь нисэх буудал								
	Жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад хуулиар тогтоосон хугацаанд ирүүлээгүй.	1	-					1	-
	Бүсчилсэн хөгжил-зүүн бүсийн нисэх буудлуудын форум сургалтын арга хэмжээнд зориулж бичиг хэрэг, хэвлэлийн зардалд 4,800.0 мянган төгрөгийг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан.	1	4,800.0					1	4,800.0
	Шилэн дансны мэдээллийн цахим санд нийт 521,427.7 мянган төгрөгийн 28 гүйлгээ мэдээлэхээс 71,560.0 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй.	1	71,560.0					1	71,560.0
	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 19,930.7 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 1 өрөө 17.95 м.кв талбай бүхий орон сууц эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээгүй.	1	19,930.7					1	19,930.7

**Иргэний нисэхийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	Байгууллагын бүтэц, орон тоо, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулаагүй, тайлант хугацаанд зарим ажилтнуудыг сард хуулиар тогтоосноос илүү буюу 297 хүртэл илүү цагаар ажиллуулж, 12,405.8 мянган төгрөгийн хөлс олгосон.	1	12,405.8					1	12,405.8
	Нийт дүн	5	108,696.5	-	-	-	-	5	108,696.5
3	Өвөрхангай нисэх буудал								
	Шатахуун худалдан авахдаа тендер зарлаагүй.	1	40,505.0				1	40,505.0	
	Нийт дүн	1	40,505.0	-	-	1	40,505.0	-	-
4	Увс нисэх буудал								
	Шилэн дансанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг байршуулаагүй.	1	262,871.3					1	262,871.3
	Нийт дүн	1	262,871.3	-	-	-	-	1	262,871.3
	НИЙТ ДҮН	34	13,134,356.3	-	-	4	697,678.7	30	12,436,677.6